


АХБ

ЖЕНДЭРИЙН ШАЛГУУР ЖАГСААЛТ

(Gender Checklist)



ХОТ БАЙГУУЛАЛТ,
ОРОН СУУЦ

Агуулга

Жендэрийн шалгах жагсаалтын зорилго	
Хот хөгжил ба орон байрны төсөлд жендэрийн асуудал яагаад чухалд тооцогддог вэ?	1
Төслийн мөчлөгийн гол асуудлууд болон үйл ажиллагаа	5
Жендэрийн дүн шинжилгээ	8
Төсөл боловсруулах	18
Бодлогын хэлэлцүүлэг	32
Хавсралт: Жендэрийн мэргэжилтний ажлын удирдамж	34
Эх сурвалжуудын түүвэр	35

Товчлол

ҮАМҮ	Үр ашгийн мониторинг болон үнэлгээ
ОНБ	Олон нийтийн байгууллага
ХБГО	Хөгжиж буй гишүүн орон
ЖХ	Жендэр ба хөгжил
АНҮ	Анхдагч нийгмийн үнэлгээ
ХҮ	Хяналт ба үнэлгээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТҮАҮЗ	Тогтвортой үйл ажиллагаа ба урсгал засвар
ТБТТ	Төслийг бэлтгэх техникийн туслалцаа
ЕЯТЗ	Ерөнхийлөгчид явуулах тайлан болон зөвлөмж
НҮ	Нийгмийн үнэлгээ
БОНХГ	Байгаль орчин, Нийгмийн хөгжлийн газар
АҮХ	Ажил үүргийн хуваарь
ХДЭ	Хөгжил дэх эмэгтэйчүүд
ХБОС	Хот байгуулалт, орон сууц
УХБ	Ус хэрэглэгчдийн бүлэг

Энэхүү баримт бичгийг олон нийтийн хүртээл болгох зорилгоор монгол хэлнээ хөрвүүлсэн боловч англи хэл нь Азийн хөгжлийн банк (АХБ)-ны албан ёсны хэл тул зөвхөн англи хэл дээрхи эх хувийг нь албан ёсных хэмээн үзнэ. Иймд иш татахдаа англи эхийг ашиглана уу. АХБ орчуулгын үнэн зөв эсэх талаар баталгаа өгөхгүй бөгөөд эх хувиас утга нь гажсан тохиолдолд аливаа хариуцлага хүлээхгүй болно.

Гарын авлагын зорилго

Энэхүү гарын авлага нь Жендэр ба Хөгжил (ЖХ)-ийн талаарх Банкны бодлого, стратегийн зорилгыг хэрэгжүүлэхэд нь АХБ-ны ажилтнууд болон зөвлөхүүдэд туслалцаа үзүүлэх зорилготой. (АХБ-ны Жендэр ба Хөгжлийн бодлогыг үзнэ үү, 1998 оны 6-р сар). Хот байгуулалт, орон сууцны (ХБОС)-ны төслүүдийг хэрэгжүүлэх төслийн үе шат бүрт тухайн төсөлд оролцож буй хүмүүст тэдгээрийн гүйцэтгэх үүрэг болоод хариуцлага, шаардлага, нэн тэргүүнд тавигдах асуудлуудыг тодорхойлох, стратеги боловсруулах, түүний бүрэлдэхүүн хэсгүүд болон үзүүлэлтүүдийг боловсруулах явцад жендэрийн мэдрэмжтэй хандахад хөтөч болно. АХБ-ны ажилтнууд төсөлд бэлтгэх техникийн туслалцаа (ТБТТ)-г хэрэгжүүлэх үеийн судалгааны үе шатанд анхдагч нийгмийн үнэлгээ (АНҮ)-г хийхдээ энэхүү гарын авлагыг ашиглан жендэрийн дүн шинжилгээ хийнэ. Зөвлөхүүд ТБТТ үе шатанд илүү нарийвчилсан байдлаар ашиглах нь зүйтэй. Түүнчлэн АХБ-ны ажилтнууд, ХБГО-ны албан тушаалтнууд болон зөвлөхүүд мөн төслийн хэрэгжилт болон төслийн хяналт ба үнэлгээ (ХҮ)-ний үед ашиглаж болно. Гэвч энд дурдагдах асуултууд бүх төсөлд хамаарахгүй бөгөөд АХБ-ны ажилтнууд болон зөвлөхүүд тухайн нөхцөл байдалд уялдуулан асуудлаа сонгон ажиллана. ХБОС-ны төслүүдэд жендэрийн асуудлыг зонхилох чиг хандлага болгосон сайн туршлагыг харуулах зорилгоор ТБТТ-ны судалгаа, төслийн

хэрэгжилт, болон ХҮ-ний талаар жендэрийн мэдрэмжтэй ажлын удирдамж боловсруулах, удирдамж бэлтгэх зааварчилгаа, мөн түүнчлэн жендэрийн асуудлыг оруулж АХБ-наас амжилттай хэрэгжүүлсэн төслүүдийн талаар шигтгээ болгон орууллаа.

Энэхүү хяналтын хуудсыг АХБ-ны *«Төслүүдэд нийгмийн асуудлуудыг оруулах нь»* гарын авлага (1994), *«Үр ашгийг тооцох мониторинг болон үнэлгээний зааварчилгаа»*, *«Хөгжил дэх эмэгтэйчүүд»* цувралуудтай хамт ашиглаж болно. Хот суурин газрын хөгжлийн асуудал нь усны хангамж болон ариун цэврийн асуудлуудтай нягт уялдаатай учир *«Усны хангамж болон ариун цэврийн асуудлуудад жендэрийн хяналтын хуудас»*-г /2000 он/ мөн ашиглах боломжтой. Бусад хэрэгцээтэй лавлагааны жагсаалтыг энэхүү гарын авлагын арын хуудаснаас үзэж болно. Гарын авлагыг АХБ-ны Байгаль орчин, нийгмийн хөгжлийн газрын Нийгмийн хөгжлийн хэлтэсийн (БОНХГ)-ийн ажилтан Сономи Танака, орон тооны зөвлөх Пенелопе Шоэффелийн бэлдсэн төслийг ашиглан НХХ-ийн Ширийн Латифийн удирдамжийн дагуу боловсруулсан болно.

Эхийг Мэри Энн Асико хянан тохиолдуулж эх бэлтгэлийг хийхэд Хун дела Круз, Элиса Ласерона хэвлэлтэнд тус тус туслалцаа үзүүлсэн болно.

Хот байгуулалт, орон сууцны төслүүдэд жендэр яагаад чухал вэ?¹

Хот байгуулалт, орон сууц нь (ХБОС) нь дараах дэд салбаруудыг хамардаг. Үүнд: усан хангамж, хог хаягдлын менежмент, усны хоолой, тээвэр, цахилгаан эрчим хүчний хангамж, орон сууцны хангамж, газар ашиглалт, түүний төлөвлөлт, ядуус амьдардаг хорооллын нөхцөл байдлыг сайжруулах, ариун цэвэр, эрүүл ахуй, байгаль орчны менежмент ба ажлын байр бий болгох эдгээр болно. ХБОС-ны төслүүд нь гол төлөв нийгмийн асуудал нь орхигдсон, хүн амын төвлөрөл ихтэй газрыг хамардаг билээ. Олон асуудлыг энд хамруулан авч үзэх боловч жендэрийн асуудал чухал учраас үүнийг орхигдуулж болохгүй. Урьд өмнө АХБ болон бусад донорын байгууллагуудаас санхүүжүүлсэн ХБОС-ны төслүүдээс олж авсан туршлагаас үзэхэд дараахь сургамжууд жендэрийг асуудлыг нэн тэргүүнд авч үзэхийн чухалыг харуулж байна:

Сургамж 1. ХБОС-ны хувьд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үүрэг, хэрэгцээ болон ойлголт нь өөр байдаг. Тэдгээрийн санал бодлыг харгалзан тэдэнд чиглэгдсэн хүчин чармайлтууд нь төслийг боловсруулах болон хэрэгжүүлэхэд эергээр нөлөөлдөг.

Эмэгтэйчүүд нь ус зөөх, тээвэрлэх, хэрэглээ болон удирдлага, мөн өрх болон орон нутаг, ард иргэдэд түшиглэсэн ариун цэврийг сахих үйл ажиллагаанд тэргүүлэх байр эзэлдэг байна. Мөн эмэгтэйчүүд хог хаягдал болон байгаль орчны менежментэд тэргүүн үүрэг гүйцэтгэдэг байна. Эмэгтэйчүүд өрхийн гэрийн ажилд гол хариуцлагыг үүрдэг тул орон сууцны шинэ буюу илүү сайжруулсан загвар хийц, үүнд гэрэлтүүлэг ба агааржуулалтын загвар хийц нь эмэгтэйчүүдийн хэрэгцээг тусгасан байх ёстой юм. Үүнээс гадна зарим тохиолдолд айл өрхийг цэвэр болон бохир усны

¹ - Энэхүү хэсэг нь гол төлөв АХБ (2000), Фонг ба бусдууд (1996) болон Воронлук ба Шалквик (1998) дээр үндэслэсэн болно.

Эмэгтэйчүүдийн орон байр, хүүхдийн асрах газар, болон ажилчин эмэгтэйчүүдийн дотуур байрыг барих асуудлыг хот суурин газрын нэг хэсэг болгон төлөвлөн тооцох.
Тээврийн үйлчилгээний хувьд өртөөнүүдэд ариун цэврийн тусгай байр барьж зөвхөн эмэгтэйчүүдэд зориулсан автобусны үйлчилгээ болон галт тэрэгний тусгай хэсгийг бий болгох асуудлыг авч хэлэлцэх.

сүлжээтэй холбохдоо эмэгтэйчүүдийг зорилтот бүлгээ болгон сонгон авах нь зорилтот бүлгээр бус ерөнхийлөн авч үзэхээс илүү их үр дүнд хүрэх талтай. Энэ нь олон нийтийн, хувийн хэвшлийн салбар, санхүүгийн хүндрэлтэй байгаа үйлчилгээний газруудын хувьд маркетингийн стратегийн чухал үр дагавартай байдаг.² Гэвч олон оронд шийдвэр гаргах байгууллагууд эмэгтэйчүүдийн үзэл бодлыг харгалзан үздэггүй. ХБОС-ны төслүүд нь эдгээр бэрхшээлийг арилгах боломжийг бий болгодог.

Сургамж 2. Жендэрийн асуудлыг оруулах нь олон үр ашигтай байдаг.

ХБОС-ны төслүүдэд жендэрийн асуудлыг авч үзсэнээр тоног төхөөрөмжийг зөв сонгон авах, түүнтэй холбоотой засвар үйлчилгээг

² Дэлхийн Банкны санхүүжилттэй Индонезид хэрэгжиж буй Сулавеси, Ириан Жайа-ийн Хот хөгжил төсөл ус хангамжийн PDAM компани нь усны сувагт холбогдох хүсэлтэй хэрэглэгчдийн тоо бага байгаагаас санхүүгийн хүндрэлд оржээ. Төв Сулавесийн Палу хотын хоёр дэд дүүргийг усны хангамжтай холбохоор туршилтын журмаар сонгож нэг дэд дүүрэгт эмэгтэйчүүдийг хэрэглэгч болгон сонгон авч нөгөө дэд дүүрэгт эрэгтэйчүүдийг зорилтот бүлэг болгон сонгожээ. Дөрвөн сарын хугацаанд маркетингийн ажилтан нар иргэдийн оролцоотой хурал зохион байгуулах замаар маркетингийн эрчимтэй үйл ажиллагаа явуулж, хэвлэмэл хуудас тарааж, айл өрхтэй биечлэн уулзалт зохион байгуулжээ. Эмэгтэйчүүдийг зорьсон маркетингийн кампанит ажил (450 өрхөөс 30 өрх) хийж эрэгтэйчүүдийн зорилтот бүлгийнхээс 450 өрхөөс 5 өрх нь хамрагдсан байна. Туршилт хийсэн бүлгийн хэмжээ нь богино хугацаанд гарч байгаа үр дүнг тооцож байгаа болохоор бага байсан байж болох талтай. Гэвч ч цэвэр усны хэрэглэгчийн хувьд эмэгтэйчүүдийг сонгосон маркетингийн стратеги нь цэвэр усны холболтын тоог өсгөхөд тус дөхөм болохыг энэхүү судалгаа харуулж байна. Энэ нь эмэгтэйчүүд ахуйн усны удирдлагад тэргүүн үүрэг гүйцэтгэдэгтэй холбоотой юм. Нөгөөтэйгүүр өрхийн хэмжээнд эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах эрх мэдэл орон бүрт өөр өөр байдаг тул нийт дэлхийн хэмжээнд энэ нь үнэн зөв бус байж болох юм (Харьятинингсх 1997).

түргэн шуурхай хийх, ариун цэврийн талаар төслийн ашиг хүртэгсэд сайн ойлголттой болох зэрэг жишээнүүд дээрээс харагдаж байна. Бусад үр ашгаас дурдвал:

- **Эдийн засгийн үр ашиг:** Хот суурин газрын дэд бүтэц, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах нь эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, бүтээмжийг сайжруулж улмаар тэдэнд ахуйн илүү сайн нөхцлийг бүрдүүлж өгнө. Мөн ус зөөх, ариун цэвэр сахих үйл ажиллагаанд зарцуулж буй цагийг багасгаснаар эмэгтэйчүүдэд орлого олох бизнес эрхлэх, гэр бүлийн гишүүд болон өөртөө илүү анхаарал тавих, амрах цаг нь уртсах боломжтой. Иймд эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.
- **Хүүхдүүдийн хүртэх үр ашиг:** Ус зөөх ажлаас чөлөөлөгдсөнөөр хүүхдүүд, ялангуяа охид сургуульд авах боломжтой болно. Тэдний эрүүл мэнд ч сайжирна.
- **Эмэгтэйчүүдийг чадавхжуулах:** ХБОС-ны төсөлд эмэгтэйчүүдийн орлого олох ялангуяа зээл авахад хамруулж тэднийг чадваржуулах нь чухал (Хайрцаг 2-г үзнэ үү).

Сургамж 3. Жендэрийн асуудлыг ядуучуудын хэрэгцээ шаардлагыг харгалзан, мөн сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар оруулах нь илүү оновчтой.

Олон нийт, хувийн хэвшилд нь ядуурлыг бууруулах болон төслийн ашиг хүртэгсдийн оролцоог нэмэгдүүлэх нь ХБОС-ны менежментийн үр дүн болон цаашдын тогтвортой байдлыг хангахад гол хүчин зүйл юм.

Орон байрны хөгжил болон бүлгээр оролцох бусад үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн идэвхитэй оролцоог дэмжихийн тулд эмэгтэйчүүдэд зориулсан манлайлал болон удирдлага менежментийн сургалтыг төсөлд оруулах.

ХБОС-ны төсөл нь тухайлбал, өрх толгойлсон эмэгтэйчүүд болон эдгээр өрхүүдийн онцгой хэрэгцээг тодорхойлох замаар жендэр болон ядуурлын хоорондын харилцан хамааралд анхаарлаа хандуулах ёстой. Ядуусын хороололд олон эмэгтэйчүүд өрх толгойлдог тул энэ нь ялангуяа ядуусын хорооллын хөгжилд чухал ач холбогдолтой. Эмэгтэйчүүд төслийг боловсруулах, барилга, сургалт болон мониторинг болон үнэлгээний явцад хэрхэн оролцож байгаа анхаарч судлах ёстой.

Эмэгтэйчүүдэд хүрч ажиллахын тулд орон нутгийн байгууллагууд, үйлдвэрчний эвлэл, эмэгтэйчүүдийн бүлгүүд болон шашны бүлгүүдийн мэдээллийн сувгуудыг ашиглах. Мөн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээллийн хэлбэр, мэдээллийн кампанит ажлыг явуулах хувиарийг нарийн төлөвлөх хэрэгтэй. Эмэгтэйчүүдийн хувьд радио, ТВ болон сурталчилгааны самбар нь сонин хэвлэлээс илүү үр дүнтэй байдаг. Арилжааны зар сурталчилгааг эмэгтэйчүүдийг гэртээ, илүү зав чөлөөтэй байхад нь явуулах нь зүйтэй.

Сургамж 4. Олон нийтэд тулгуурласан арга нь оновчтой, сурах ба суралцах үйл явцад чиглэгдсэн байх нь зүйтэй. Иймд төслийн удирдлага болон эмэгтэй, эрэгтэй төслөөс ашиг хүртэгсдийн хооронд байнгын хэлэлцүүлэг явуулж байх нь чухал.

Төслөөс ашиг хүртэгсдэд хангалттай цаг хугацаа өгч, төслийн уян хатан загварыг сонгох боломж олгож, засаж залруулах эрх мэдэл олговол төсөл нь жинхэнэ эзэндээ хүрч чадна. Ингэснээр тэд төсөл хэрэгжүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчидтэй төслийн бүрэлдэхүүн хэсгүүд дээр нарийвчлан ярилцах боломж бий болно. Энэ үйл явцад эмэгтэйчүүдийг оролцуулахгүй байх нь элбэг тохиолддог. Иймээс ашиг хүртэгсэд болон үйлчилгээ үзүүлэгчдийн хооронд хоёр талт харилцааг бий болгох боломж олгох механизмыг төсөлд тусгаж өгөх шаардлагатай.

Төслийн үе шатуудад анхаарах гол асуултууд ба үйл ажиллагаа

Төслийн бүхий л шатанд жендэрийн асуудлыг тодорхойлж оруулахад гурван гол хэрэгслийг ашигладаг. Үүнд: жендэрийн дүн шинжилгээ, төслийг боловсруулах явц, бодлогын хэлэлцүүлэг зэрэг болно. Жендэрийн дүн шинжилгээ гэдэг нь төслийн бэлтгэл техникийн тусалцаа (ТБТТ)-ны судалгааны үе шатны анхдагч

Зөвлөлдөх уулзалтыг төлөвлөхдөө эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд оролцоог адил тэгш хангана. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдтэй тус тусад нь уулзаж ярилцах нь эмэгтэйчүүдийг үзэл бодлоо илүү нээлттэйгээр илэрхийлэх боломжийг олгож тэдний дуу хоолой бусдад хүрнэ. Хамтарсан хуралд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн суудал хуваарилалтыг мөн бодолцох хэрэгтэй.

нийгмийн үнэлгээ (АНҮ) болон ТБТТ-ны хэрэгжилтийн үе дэх нийгмийн үнэлгээ (НҮ)-ний бүрэлдэхүүн хэсгүүд юм.

Жендэрийн мэдрэмжтэй төсөл боловсруулахдаа жендэрийн дүн шинжилгээн дээр үндэслэх бөгөөд үүнийг ТБТТ-ны эцсийн тайлан болон Ерөнхийлөгчид явуулах тайлан ба зөвлөмж (ЕЯТЗ)-д тусгана.

Хөгжиж буй гишүүн орон (ХБГО)-ны хэрэгжүүлэгч болон бусад агентлагуудын хооронд явуулах бодлогын хэлэлцүүлэгийг төслийн бүхий л шатанд явуулах хэрэгтэй. Төслийг төлөвлөх, төслөөс ашиг хүртэгсэдтэй санал солилцох үед гарч ирсэн жендэрийн судалгаанаас гарсан дүгнэлт ба зөвлөмжүүд цаашдын үйл ажиллагаандаа анхааран ажиллах нь зүйтэй.

Хүснэгт 1

Төслийн үе шатуудад жендэрийн асуудлыг оруулах: Авах гол арга хэмжээнүүд

ТӨСЛИЙН МӨЧЛӨГ	ХАРИУЦАХ ЭЗЭН	АВАХ АРГА ХЭМЖЭЭ
ТБТТ-ны судалгааны үе дэх АНУ	Төлөөлөгчдийн ахлагч/Зөвлөх	<ul style="list-style-type: none"> ТБТТ-ны жендэр болон эмэгтэйчүүдийн оролцооны гол асуудлууд болон цаашид шаардагдах мэдээллийг тодорхойлох. Төслийн зорилгод жендэрийн үүргийг тодорхойлох. ТБТТ-ны жендэрийн мэргэжилтэн буюу нийгмийн ухааны мэргэжилтний Ажил үүргийн хуваарийг (АҮХ)-г бэлдэх.
ТБТТ-ны нийгмийн үнэлгээ (НУ)	Зөвлөх, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Байгаль орчин, нийгмийн хөгжлийн газар (БОНХГ) болон ХБГО-ны түнштэй хамтрах	<ul style="list-style-type: none"> НУ-ний нэг хэсэг болох жендэрийн дүн шинжилгээг хийх. Зорилтот бүлгүүд, сонирхогч талуудын нийгэм-эдийн засгийн байдлыг гаргах, жендэрийн ялгавартай мэдээллийг гаргах. Мэдлэг, хандлага, зуршил, аж төрөх хэв маяг, шаардлага, хэрэгцээ болон хүчин зүйлсүүдийн жендэрийн ялгаатай байдлыг судлах. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцооны чадавхи болон түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг үнэлэх Жендэрээр ялгаварлаж болзошгүй төслийн үр нөлөө болон төслийн үр өгөөжийг аль болох дээшлүүлэх, сөрөг нөлөөг аль болох багасгах хувилбаруудыг үнэлж гаргах. ТБТТ болон төслийг хэрэгжүүлэх үед хамтран ажиллах төрийн болон төрийн бус байгууллагууд (ТББ), орон нутаг, олон нийтэд түшиглэсэн байгууллагууд (ОНТБ) болон эмэгтэйчүүдийн бүлгүүдийг тодорхойлох. Тэдгэрийн чадавхид үнэлгээ өгөх. Холбогдох бодлого ба хууль тогтоомжийг (жишээ нь өв залгамжлах тухай хууль, ус хэрэглэгчдийн бүлгүүдийн дүрэм журам г.м.) хянах. Дээр дурьдсан асуудлуудтай холбоотой мэдээллийн цоорхойг олж тогтоох. Төслийг боловсруулахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн оролцоог тэгш хангах Төслийг боловсруулахдаа жендэрийн дүгнэлт саналыг оруулах
ЕЯТЗ ба зээлийн гэрээг төлөвлөж эцэслэх	Төлөөлөгчдийн ахлах, БОНХГ	<ul style="list-style-type: none"> Төслийн холбогдох бүрэлдэхүүн хэсгүүдэд (үүнд төслийн зорилго, цар хүрээ, ядуурал болон нийгмийн зүгээс авах арга хэмжээ, зардлын тооцоо, байгууллагын бүтэц зохион байгуулалт, нийгмийн үнэлгээний хавсралт, төслийн хэрэгжилтнэд оролцох зөвлөхүүдийн ажлын удирдамж, ХҮ-ний явцад жендэрийн асуудлыг оруулах тусгах Төслийн ангиллыг жендэр болон хөгжлийн зорилттой уялдуулах. ХБГО-ны засгийн газрын буюу үйлчлүүлэгчийн зүгээс авах арга хэмжээ болон хэрэгжүүлэх явдлыг хангах үүднээс гэрээнд жендэрийн талаар авах шаардлагатай арга хэмжээний жагсаалтыг гаргах.
Зээлийн хэлэлцээр	Төлөөгчдийн ахлах	<ul style="list-style-type: none"> Авах ёстой арга хэмжээний жагсаалтыг тусгай нөхцөл болгон оруулах.
Хэрэгжүүлэлт	Төслийн газар, ХБГО-ны ажилтнууд	<ul style="list-style-type: none"> Төслийн явцын тайланг хянах үзэх Шаардлагатай бол төслийг дахин шинэчлэн боловсруулах
Үр ашгийн мониторинг ба үнэлгээ (АШМУ)	Төслийн газар, ХБГО-ны ажилтнууд	<ul style="list-style-type: none"> Жендэрийн ялгавартай үнэлгээг бий болгох Шаардлагатай бол төслийг дахин шинэчлэн боловсруулах

Жендэрийн дүн шинжилгээ³

Төслийн жендэрийн дүн шинжилгээ нь ихэвчлэн АНУ эсвэл НҮ-ний нэг хэсэг болгон хийгддэг. Төслийн цар хүрээ, онцлог байдлаас хамааран ТБТТ хэрэгжилтийн үе шатанд жендэрийн дүн шинжилгээг хийх нэгээс гурван сарын хугацаагаар зөвлөх авч ажилуулах шаардлагатай. Мөн ямар аргачлалыг хэрэглэх вэ гэдэгт анхааралаа хандуулах ёстой. Уг дүн шинжилгээг хийхдээ ямар асуудлуудыг голлон чухалчилж авах вэ гэдгийг дор дурьдав. Үүнд:

Аргачлал

Бэлэн байгаа бичиг баримт дээр үндэслэн анализ хийх

- ХБОС-ын чиглэлээр урьд хэрэгжиж байсан талаар мэдээлэл, түүнчлэн төслийн зорилтот бүлгүүдийн нийгэм-эдийн засгийн байдлын талаарх танилцуулга зэрэг материал, мэдээллийг хянаж үзэх (жишээ нь статистикийн мэдээ, ядуурлын талаарх судалгаа, жендэрийн судалгаа, доноруудаас санхүүжүүлсэн ХБОС-ийн өмнөх төслүүдийн бичиг баримт).
- Холбогдох хууль эрх зүйн (өв залгамжлалын тухай хууль, гэр бүлийн тухай хууль, зээлийн зохицуулалт г.м.), бодлогын (ус, хог хаягдал буюу орон сууцны төлбөрийн татаасын тухай бодлого г.м.) болон бүтэц зохион байгуулалтын тогтолцоо (дэд бүтцийн үйлчилгээг үзүүлэхэд тухайн хот суурин газрын одоогийн засаг захиргааны тогтолцоо), жендэрийн үр дагаврыг хянаж үзэх.

Өрхийн судалгаа (дэлгэрэнгүй мэдээллийг «Цуглуулах тоо баримт» гэсэн хэсгээс үзнэ үү)

- Жендэрийн ялгавартай нийгэм-эдийн засгийн бүтцийн зургийг гаргаж зорилтот хүн амын ХБОС-ны практик үйл ажиллагаанд оролцож байсан туршлага, шаардлага, хэрэгцээ болон төлбөрөө төлөх эрмэлзэлтэй эсэх зэргийг тодорхойлох.
- Тоон мэдээллийг цуглуулах.

³ - Энэ хэсэг гол төлөв Воронлук ба Шалквкийн судалгаан дээр үндэслэсэн болно (1998).

Оролцооны аргачлалууд (оролцооны аргаар үнэлгээ хийх, зорилтот бүлгүүдийн хэлэлцүүлгүүд, түүвэрчилсэн ярилцлага, сонирхогч талуудтай очиж уулзах)

- Судалгаагаар цуглуулах боломжгүй чанарын мэдээллийг цуглуулах.
- Эрэгтэй, эмэгтэй төслөөс ашиг хүртэгсэд болон бусад сонирхогч талууд, ялангуяа ядуу эмэгтэйчүүдэд төсөлд оролцох боломжийг бий болгох арга замыг хайх.
- Зорилтот газар нутгийн зургийг гаргах. Үйлчилгээний хүртээмж ба ядуурлын түвшний хувьд хамгийн их эмзэг газрууд хаа байна вэ?
- Сонирхогч талуудын гол бүлгүүд болон тэдний оролцоог тодорхойлох.

Боловсон хүчин

- Төслийн багуудын жендэрийн зохистой тэнцвэрийг хангах.
- Жендэрийн талаар ойлголттой, орон нутаг, ёс заншлын талаар мэдлэгтэй, сонсох эрмэлзэлтэй, зэрэг үзүүлэлтүүдээр төслийн багийн гишүүнийг сонгох.

Цуглуулах тоо баримт

Макро төвшний бүтэц зохион байгуулалт, тогтолцоо

- Салбарын бодлого болон хууль эрх зүй, бүтэц зохион байгуулалтын тогтолцоонд жендэрийн үзүүлэх нөлөө.
- Хэрэгжүүлэгч агентлагийн чадавхи ба жендэрийн асуудлыг анхаарч үзэх хүсэл эрмэлзэл.

Нийгэм-эдийн засгийн танилцуулга

- Хүн амын судалгаа
 - Дэд бүс, хүйс, үндэс угсаа буюу каст, нас

ЗӨВЛӨМЖ

Төслийн багийн

гишүүнчлэл хүйсийн

хувьд тэнцвэртэй

байгааг эсэхийг

харгалзан үзэх

ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомж,

дүрэм журмын

жендэрийн үр

дагаврыг хянаж үз

- Шашны байдал ба ялгаа
- Нүүдэллэж ирж байгаа , явж байгаа хандлага (эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд)
- Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн эзэлж буй хувь
- Өрхийн хэмжээ, хамаарлын харьцаа ба бүтцийн загвар (өнөр гэр бүл - үндсэн гэр бүл)
- Гэрлэх насыг хүйсээр ялгавартайгаар судлах

■ Ядуурал ба хөдөлмөр эрхлэлт

- Өрхийн орлогын түвшин болон хувь хүмүүсийн орлогын эх үүсвэр, хүйсээр, насаар
- Өрхийн зарлагын хэв маяг ба шийдвэр гаргах хүйсээр
- Ядуурлын дүр зураг (ядуурлын түвшнөөс доогуур амьжиргаатай хүн амын эзэлж буй хувь, орлогын хуваарилалт, ядуурал ихтэй дүүрэг хороолол, ядуурлын шинж чанар ба шалтгаан, ядуучуудын амь зуулгын стратеги)
- Ядуурал жендэрийн харилцан хамаарал (эмэгтэйчүүд толгойлсон өрх, ядуурлын түвшний хоорондын холбоо, ядуурлын эмэгтэйчүүдэд үзүүлж буй ачаалал)
- Гэртээ ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзэлж буй хувь ба ажлын төрөл
- Гэрээсээ гадуур ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн хувийг тогтоож, амар ажил эрхэлж буйгаар нь судалгааг гаргах
- Ажилгүйдлийн түвшин, хүйсээр

■ Газар ашиглалт ба түрээс

- Түрээс болон эзэмшлийн байдал (эзэмшлийн ба түрээсийн орон сууцны харьцаа)
- Түрээс эсвэл эзэмшлийн үндсэн дээр байгуулсан иргэдийн оролцоотой бүлгүүд, (түрээслэгчдийн нийгэмлэг г.м.)

ЗӨВЛӨМЖ

Гэрээр ажил

эрхэлж буй

эмэгтэйчүүд болон

гадуур ажилладаг

эмэгтэйчүүдийн

харьцааг гарга

- Орон сууц эзэмшдэг эсвэл түрээслэгчээр бүртгүүлсэн эмэгтэйчүүдийн хувь
- Зөвшөөрөлгүй оршин суугчдын тоо ба байршил (эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд)
- Оршин сууж байгаа хугацаа

■ Эрүүл мэнд

- Хүн амын өсөлтийн хувь
- Нярай болон эхийн эндэгдлийн хувь (эрэгтэй, эмэгтэй)
- Үйлчилгээний хүртээмж ба газар зүйн тархалт
- Төрөлтийн түвшин болон шийдвэр гаргах
- Өрхийн хоол хүнсний хуваарилалт болон тэжээллэг байдал , хүйсээр
- Гэр бүлийн хүчирхийлэл

■ Боловсрол ба хүүхдүүд

- Бичиг үсэгт тайлагдах ба сургуульд элсэгчдийн байдал , жендэрээр
- Сургуулиас завсардсан хүүхдийн тооны харьцаа, жендэрээр
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, гудамжны хүүхдийн тоо, жендэрээр

■ Эмэгтэйчүүдийн байдал

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн цар хүрээ (гэр бүлийн г.м.)
- Улс төрд эмэгтэйчүүдийн төлөөлөл болон тэр талаарх мэдлэг
- Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн нийгэм-соёлын ойлголт болон бодит байдал
- Жендэрээр ялгаварлан гадуурхах бодлого ба хууль тогтоомжууд
- Хууль эрх зүй , шударга ёс, ялангуяа хүчирхийлэл болон эрүүгийн гэмт хэрэг

ЗӨВЛӨМЖ

Жендэрээр

ялгаварлан

гадуурхдаг нийгэм-

эдийн засгийн

хэм хэмжээ болон

хууль тогтоомж

нь эмэгтэйчүүдэд

хэрхэн нөлөөлдөг

талаар үнэлгээ хийх

- Жендэрийн үүрэг ба хариуцлага
 - Үйлдвэрлэл (хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хөдөлмөрийн жендэрийн хуваарь, орлого хуримтлуулах үйл ажиллагаа.) болон нөхөн үржихүй (өрхийн гэрийн ажил, хүүхэд харах, халамжлах г.м.)-н үүрэг хариуцлагын жендэрийн хувиарлалт, уг ажилд зарцуулж буй цаг хугацаа

Хот суурин газрын нийтийн болон аж ахуйн үйлчилгээний талаарх мэдлэг, хандлага бодит байдал

- ХБОС-ны дэд бүтэц ба үйлчилгээний хүртээмж (ус хангамж, бохир ус ба хатуу хог хаягдлын менежмент, зам, цахилгаан, орон сууцны хүртээмж, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, нийтийн гэрэлтүүлэг, тээвэр г.м.)
 - Үйлчилгээг хэн үзүүлдэг вэ (орон нутгийн засаг захиргаа, ТББ, хувийн компани г.м.)?
 - Өрхүүдийн хэдэн хувь нь дээрхи үйлчилгээнүүдэд хамрагдах боломжтой вэ?
 - Үйлчилгээнд хамрагдахад жендэрийн ялгаварлал байдаг эсэх?
- ХБОС-ны үйлчилгээний чанар (үйлчилгээний төрөл тус бүрээр)
 - Үйлчилгээ нь тогтмол эсэх?
 - Үйлчилгээний хүртээмж, тоо буюу чанар нь улирлын байдлаас шалтгаалдаг эсэх ?
 - Үйлчилгээнд сэтгэл ханамжтай эсэх? Тэдгээрийг хэрхэн сайжруулах вэ?
- Үйлчилгээний өртөг болон түүнийг төлөх эрмэлзэл (үйлчилгээ хэлбэр)
 - Үйлчилгээний төлбөр?
 - Төлбөрийг хэн (өрхийн эрэгтэй нь буюу эмэгтэй нь) хэнд (хэрэглэгчдийн хороонд, орон нутгийн засаг захиргаанд, хувийн компанид г.м.) төлдөг вэ?
 - Үйлчилгээний хөлс ямар байна? Төлбөрийн хэмжээ бодитой эсэх хүмүүс төлөх боломжтой эсэх?

ЗӨВЛӨМЖ

ХБОС-ны

үйлчилгээний

хүртээмжид гарч

буй ялгааг тогтоож

үйлчилгээний

хүртээмжид гарч буй

жендэрийн ялгааг

тодорхойлох

- Үйлчилгээний чанар сайжирахад хүмүүс төлбөрөө төлөх сонирхол нь хэр зэрэг байх?

- Хувийн, хувь хүмүүсийн, эсвэл хууль бусаар үйлчилгээг хүртэх
 - Усан хангамж: Албан ёсны үйлчилгээнээс гадна усны өөр ямар эх үүсвэр байдаг вэ (дундын булаг шанд, горхи, гол, усан сан, хувийн усан сан, дундын худаг г.м.)? Эдгээр нь хир зэрэг хол байрладаг вэ? Усыг хэн (эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд) хэрхэн зөөвөрлөх, тээвэрлэх, хадгалдах вэ? Үүнд ямар хугацаа зарцуулагддаг вэ?
 - Хог хаягдлыг зайлуулах: Хатуу хог болон бохир усыг зайлуулах талаар авч байгаа арга хэмжээ? Үүнд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ямар үүрэг гүйцэтгэх вэ?
 - Цахилгаан: Хууль бусаар цахилгаан ашиглаж байгаа эсэх? Ямар аргаар ?
 - Орон сууц болох орогнох байрны газрын зөвшөөрөл: Хууль бусаар зөвшөөрөлгүй оршин сууж байна уу? Оршин сууж байгаа хугацаа?
- ХБОС-ны менежмент, жендэрийн хөдөлмөр хуваарилалт
 - Тухайн өрхийн эрэгтэй нь, эсвэл эмэгтэйн аль нь ХБОС-ийн удирдан зохион байгуулахад оролцож байна вэ?
 - Тухайн өрхөд хэн нь (эрэгтэй нь, эмэгтэй нь) ус, цахилгаан ба орон сууцийн ашиглалт болон хуваарилалтын талаар шийдвэр гаргадаг вэ?

ЗӨВЛӨМЖ

ХБОС-ны удирдан

зохион байгуулах

ажлыг эмэгтэйчүүд,

эрэгтэйчүүдэд

хэрхэн адил тэгш

хуваарилах

Ариун цэвэр ба байгаль орчны талаарх мэдлэг, хандлага ба практик

- Ариун цэвэр ба байгаль орчны талаарх боловсрол: ариун цэвэр болон байгаль орчны талаар гэр бүл, сургууль буюу орон нутгийн иргэдэд сургалт гэгээрлийн ажил явуулдаг эсэх? Мэдээлэл түгээх нийтийг хамарсан өргөн хүрээтэй ажил зохиоддог вэ? Эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд асуудлыг хэрхэн ойлгож хүлээж авч байгаа?
- Ариун цэвэр сахиулах арга хэмжээнүүд
 - Эрэгтэй, эмэгтэй зориулж ариун цэврийн /бие засах газрын асуудлыг шийдсэн эсэх?

ЗӨВЛӨМЖ**Эмэгтэйчүүд,****эрэгтэйчүүдийн****асуудалд хэрхэн****тэргүүлэх ач****холбогдол өгч****байгаад талаар****мэдэх**

- Хувийн нууцыг хэрхэн хамгаалдаг вэ? Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хооронд болон гэр бүлийн гишүүдийн дундын бие засах газрыг ашиглахад ямар нэгэн буруу ташаа ойлголт байдаг эсэх?

- Хатуу хог ба усны хоолой
 - Хатуу хогийн хаягдыг хэн цуглуулж хаядаг вэ?
 - Хогийг дахин боловсруулдаг эсэх? Хогийг хэн цуглуулдаг вэ (нийтээрээ, жижиг дунд боловсруулах үйлдвэр г.м.)?

Хүртээмж ба хяналтанд гардаг хүндрэлүүд (ХБОС-ны бус асуудлууд)

- Үйлдвэрлэлийн нөөц эх үүсвэр болон үйлчилгээний хүртээмж
 - Ажлын байр болон орлого олох боломж, зээл авах ба зах зээлд хүрэх боломжоороо эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хооронд ямар ялгаа байна вэ?
 - Үйлчилгээний хүртээмж буюу хяналтыг сайжруулахад гаднын ямар үзүүлж буй эсэх? Хэн үзүүлж буй?
- Нийгмийн үйлчилгээний боломж ба хүртээмж (эрүүл мэнд ба ариун цэвэр, бичиг үсэгт тайлагдах хөтөлбөр): Гадны тусламж буй эсэх?

Хэрэгцээ, эн тэргүүний асуудал ба хүлээж буй үр дүн

- Хэрэгцээ: Одоогийн нөхцөл нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хөгшчүүд болон хүүхдүүдийн эрэлт хэрэгцээг хангаж чадаж буй эсэх? Ямар хэрэгцээ байна? Эдгээр ялгаатай байдлын шалтгаан?
- Эн тэргүүний асуудал: ХБОС-ны төрөл бүрийн үйлчилгээнүүдэд алинд нь эрэгтэй эмэгтэй илүү ач холбогдол өгч байгаа? Ялгаатай хандаж байгаагийн шалтгаан
- Төслөөс хүлээж буй үр дүн, жендэрээр: Доорх зүйлүүд дээр эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хэрхэн ялгаатай ялгаатай хандаж байна вэ? Үүнд.

- Цаашдын төлөвлөлт, төслийг боловсруулах, болон ХҮ-нд оролцох оролцоо
- Иргэний барилга, хог хаягдал цуглуулах болон дахин боловсруулалт хийдэг аж ахуйн нэгж, барилгын материалын үйлдвэр, төслийн газруудад ажиллах боломж. Эдгээр үйл ажиллагаанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн хуваарилалт хэрхэн хийгдсэн бэ?
- Орон сууцны хөгжил ба жижиг дунд үйлдвэр болон орлого хуримтлуулах бусад үйл ажиллагаанд зориулсан зээл

Төсөлд өөрсдийн хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзэл, жендэрээр: эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд хоорондын ялгаа нь үйл ажиллагаанууд :

- Барилга, нягтлан бодох бүртгэл, бараа материал нийлүүлэлт, хоол хүнс бэлтгэл, байнгын засвар үйлчилгээ г.м. хөдөлмөр эрхлэлт
- Багахан газрыг ашиглах, орон нутгийн нөөц боломжийг ашиглах зэрэг дээр харагддаг

Төслийн үр нөлөө

Жендэрийн ялгавартай нөлөө

- Төслөөс гарч болох сайн буюу сөрөг үр дагавар? Энэ нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлөх вэ? Жишээ нь гэрээрээ аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй эмэгтэйчүүдэд «Бүсчлэлийн журам» сөргөөр нөлөөлж болох эсэх?
- Төслийн үр ашгийг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн адил тэгш хүртэж чадаж байна уу?
- Сөрөг үр нөлөөг хэрхэн бууруулах вэ?

Нийгмийн эмзэг бүлгүүд

- Нийгмийн ямар эмзэг бүлгүүд байна вэ?

ЗӨВЛӨМЖ**Төсөл эмэгтэйчүүд,****эрэгтэйчүүдэд****хэрхэн нөлөөлөхийг****тогтоож сөрөг үр****дагаврыг бууруулах****арга замыг олох**

ЗӨВЛӨМЖ**Төсөлд оролцох****оролцоо, хөдөлмөр****эрхлэх боломж ба****зээлийн хэрэгслийн****талаар төслөөс****ашиг хүртэгсдийн****хүлээж буй үр дүнг****тодорхойлох**

- Тэд хэн бэ? Хаана амьдардаг вэ? Тэдний нийгэм-эдийн засгийн байдал?
- Төсөл эдгээр бүлгүүдэд хэрхэн нөлөөлөх вэ?

- Газартай болох/Нүүн суурьших
 - Газар худалдан авах эсвэл нүүн суурьших даллах явдал хүлээгдэж байгаа эсэх? Хэр их эрчимтэй?
 - Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд үзүүлэх нөлөө?
 - Эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд нүүлгэн сууршуулах газрын талаар өөр саналтай байгаа эсэх?
 - Эмэгтэйчүүд толгойлсон ядуу өрхүүдэд нэмэлт дэмжлэг шаардлагатай байгаа эсэх?

Хөршийн холбоо/Олон нийт

- Мөн чанар
 - Ойролцоо нягт уялдаатай орон нутгийнхан байгаа эсэх? Түүний зохион байгуулалтын үндэс суурь?
 - Ард иргэд суурьшаад хэдэн жил болж байгаа вэ?
 - ХБОС-ны тодорхой үйлчилгээг хүргэхэд олон нийтийн оролцоо чухал гэдэгт төслөөс ашиг хүртэх эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд итгэж байгаа эсэх? Яагаад?
- ХБОС-ны үйлчилгээг хэрэглэх талаарх олон нийтийн бүлгүүдийн хоорондын зөрчлүүд
 - Нийтийн аж ахуйн үйлчилгээ (ус түгээлт г.м.)-ний түгээлт буюу түүний менежментийн үүрэг хариуцлагын хуваарилалт (хог цуглуулах үүрэг г.м.)-ын талаар олон нийтийн бүлгүүдийн дотор аливаа зөрчил байгаа эсэх? Хэрэв байгаа бол эдгээр зөрчил нь жендэрийн ялгаа, орлогын түвшний ялгаа, яс үндэстэн буюу кастын ялгаанаас хамаарч байна уу? Эдгээр зөрчлийг хэрхэн шийдвэрлэх вэ? Зөрчлийг шийдвэрлэхэд эмэгтэйчүүд оролцдог эсэх?

Оролцоо

- Оролцооны хүчин зүйлс
 - Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлс?
 - Ямар хөшүүрэг, ямар бэрхшээл байдаг вэ?
- Хэлбэр: Төслийн үйл ажиллагаанд оролцох ямар хэлбэрийг эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд илүүд үздэг вэ (төлөвлөлтийн шатанд гаргадаг шийдвэр, дэд бүтцийн талаар санал боловсруулах, бэлэн мөнгө хандивлах, барилгын ажил, сургалт, үйл ажиллагаа ба засвар үйлчилгээ, санхүүгийн удирдлага зохион байгуулалт, зохион байгуулалтын менежмент г.м.)? Яагаад?
- Олон нийтэд түшиглэсэн байгууллагууд (ОНТБ) ба ТББ
 - Түрээслэгчдийн холбоо, эд хөрөнгө эзэмшигчдийн холбоо, ус хэрэглэгчдийн бүлгүүд эсвэл хог хаягдлын менежментийн хөршүүдийн холбоо зэрэг албан ёсны эсвэл албан ёсны бус ОНТБ байгаа эсэх? Тэд ямар үүрэгтэй байдаг вэ? Тэд төслийн үйл ажиллагаанд оролцоход тохиромжтой эсэх?
 - Эдгээр бүлгүүдэд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалттай байгаа эсэх?
 - Ядуурлыг бууруулах, эмэгтэйчүүдийн санаачлагыг дэмждэг олон улсын буюу үндэсний ТББ байдаг эсэх? Төсөл тэдэнтэй хэрхэн холбогдож болох вэ?
 - Төслийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийг идэвхитэй оролцуулахын тулд ямар механизмыг ашиглаж болох вэ?
 - Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийг дайчилж сургахад ямар байгууллагатай хамтран ажиллаж болох вэ?

Эмэгтэйчүүдийн оролцоог хөхүүлэн дэмжихийн тулд боломжтой үед эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэх, орлого хуримтлах боломжоор хангахыг харгалзах (Хайрцаг 3-г үзнэ үү). Бүх гэрээнүүдэд ижил төрлийн ажилд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд адил хөлс төлж байх бодлогыг баримтлах.

Төслийг боловсруулах үе шат

Гол бүрэлдэхүүн хэсгүүд⁴

Дэд бүтцийн төслийн төлөвлөлт (усан хангамж, хог хаягдлын менежмент, ариун цэвэр, тээвэр болон цахилгаан хангамж ба байр орон сууц байрны хангамж)

ЗӨВЛӨМЖ

Байр орон сууцны

загвар хийцийг

бэлдэх, байршлыг

сонгохдоо

эмэгтэйчүүдийг

идэвхитэй

оролцуулж тэдний

саналыг авах;

эмэгтэйчүүдийн

гэрийн ажлыг

улам хүндрүүлэх

барилгын загвар

хийцээс зайлсхийх

■ Төслийн ашиг хүртэгч эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийг хот суурин газрын үйлчилгээний тоо, байршил болон төрлийг тодорхойлоход идэвхтэй оролцуулж тэдний эн тэргүүний асуудлуудыг оруулах. Жишээ нь, шаардлагатай үед:

- Шөнийн цагаар охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангах үүднээс зардал бага шаардагдах гэрэлтүүлэх төхөөрөмжийг замын дагуу байршуулах
- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд чөлөөтэй ашиглаж болох байруудыг бий болгох асуудлыг авч үзэх.
- Нийтийн тээвэр хот суурин газрын хөгжлийн нэг хэсэг байгаа тохиолдолд эмэгтэйчүүд чөлөөтэй ашиглаж болох цэгүүд, хуваарийг харгалзах. Эрчүүд, эмэгтэйчүүдийн тусгаарлал нь ердийн хэм хэмжээ байдаг тохиолдолд зөвхөн эмэгтэйчүүдэд зориулсан тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх асуудлыг харгалзах.
- Жендэрээр тусгаарлах нь ердийн хэм хэмжээ байдаг тохиолдолд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд тус тусад нь зориулсан байр, орон зайг бий болгох (галт тэргэнд эмэгтэйчүүдэд зориулсан вагон, зөвхөн эмэгтэйчүүдэд зориулсан автобус, автобусны буюу галт тэрэгний буудал дээр эмэгтэйчүүдэд зориулсан бие засах газар г.м.) (Хайрцаг 1-г үзнэ үү).
- Шаардлагатай тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэл дарамтад өртсөн эмэгтэйчүүд, хүүхдүүд зориулсан хамгаалах байр /худалдагсан охидуудад зориулсан түр байрлах байр, гудамжны хүүхдүүдэд зориулсан

⁴ - Энэхүү хэсэг нь Ворониук ба Шалквик (1998)-ийн судалгаа, Хабитат II-ын вэб хуудас (<http://www.cedar.ybuvue.ac.at/habitat/gender/gender.html>) болон АХБ-ны олон төслүүдийн бичиг баримт дээр үндэслэсэн болно.

асрах газар г.м./, эсвэл ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдэд зориулсан дотуур байр барих асуудлыг харгалзан үзэх. Эдгээр газруудыг хувийн хэвшлийн болон ТББ ажиллуулж болох юм.

- Хот суурин газрын нийтийн үйлчилгээний газруудад (усны гоожуур, бие засах газар)-ыг эмэгтэйчүүд хялбар хүрч болох газар байрлуулах
- Ашиг хүртэгч эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийг байр орон сууцны загвар хийц, байршлыг тогтооход идэвхитэй оролцуулж тэдний хэрэгцээ шаардлагыг тусгах. Жишээ нь:
 - Эмэгтэйчүүдийн гэрийн ажлын ачааллыг хүндрүүлэх байрны загвар хийц (шороон шал, төрөл бүрийн үйл ажиллагаа давхцах г.м.)-ээс зайлсхийх.
 - Орлого хуримтлуулах ажлыг гэрээр хийж буй эмэгтэйчүүдэд ажлын байр, агуулах болон гэрэлтүүлгээр хангах, зай багтаамжтай орон сууцны загвар хийцийг харгалзан үзэх (Хайрцаг-2 үзнэ үү). Түүнчлэн эрэгтэй эмэгтэй хүмүүс тусдаа байх шаардлагыг харгалзах үзнэ.
 - Хямд өртөгтэй орон сууцнуудыг гал тогоонд дараа нь гэр ахуйн цахилгаан бараа хэрэглэж болохоор цахилгааны монтаж, гарц суурилуулахыг харгалзан үзэх (энэ нь тухайн гэр бүлд хөдөлмөр цаг хэмнэх хэмнэдэг гэр ахуйн цахилгаан хэрэгсэл худалдаж авах зорилгоор мөнгөө хэмнэх эрмэлзлийг төрүүлж болох юм).
 - Өрхийн орлого нэмэгдэхийн хирээр орон сууцаа өргөтгөх боломж олгох энгийн загвар хийцтэй байрыг барих
 - Орон сууцны байршлыг сонгохдоо эмэгтэйчүүд ус болон ариун цэвэр, мөн тээвэр болон аюулгүй талаасаа ойр газрыг харгалзан үзэх.
- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлага болон удирдан зохион байгуулах чадавхи (усны хангамж, бие засах газар, ус суваг), тухайн орон нутгийн түүхий эд материал, ёс заншил болон хүрээлэн буй байгал орчинд тохирсон технологийг ашиглах.

ЗӨВЛӨМЖ

Зөвхөн

эмэгтэйчүүдэд

зориулсан тээврийн

хэрэгслийг

нэвтрүүлэхийг

харгалзах

ЗӨВЛӨМЖ

Эмэгтэйчүүдийн

цагийн хуваарь

эрэгтэйчүүдийнхтэй

харьцуулбал өөр

байж болох: тэд

нийтийн унаагаар

өөр цагт үйлчлүүлэх

өөр чиглэл

маршрутаар явдаг.

Иймээс эмэгтэйчүүд

хэрэглэгч гэдгээр нь

авч үз.

Хайрцаг 1

**Бангладешийн Хөдөөгийн Дэд Бүтцийн Хөгжлийн 3 дахь төсөл, 1997:
Эмэгтэйчүүдийн зах зээл болон орон байрны асуудлыг шийдвэрлэх нь****КЕЙС
СУДАЛГАА**

Бангладешийн Хөдөөгийн Дэд Бүтцийн Хөгжлийн 3 дахь төсөл нь дэд бүтцийн төслүүдэд эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээ болон тэдний оролцооны асуудлыг амжилттай шийдвэрлэж болохын тод жишээ юм. Төсөл нь зам гүүр, усны хоолой, үерийн далан, зах зээлийн газар болон завины зогсоол зэрэг жижиг хотуудын дагуух дэд бүтцийг сайжруулах асуудлыг хамарч байгаа юм. Төслийн жендэртэй холбоотой хоёр асуудлыг энд дурьдах нь зүйтэй. Үүнд:

Төвийн зах зээлийн газар эмэгтэйчүүдийг худалдаа арилжаа хийх боломжийг бий болгох

Төслийн хүрээнд эмэгтэй худалдаачдыг дэмжих зорилгоор 279 худалдааны цэгүүдийг барьсан. Зах дээр байрлах энэхүү цэгүүдийг байршлыг сонгохдоо эмэгтэйчүүд өөрсдөө төслийн удирдлагатай зөвлөлдсөн. Мөн эмэгтэйчүүдэд зориулсан бие засах газар болон ус хангамжийн байгууламж барьжээ. Зах дээрх энэ цэгүүдийг ажилуулахад эмэгтэй худалдаачдыг сонгон шалгаруулах

ХБОС-ны үйл ажиллагааны хугацааг тогтоох нь

- Хот суурин газрын үйлчилгээний цагийн хуваарийг тогтоохдоо аль болох эмэгтэйчүүдийн хэрэгцээг харгалзаж үзэх (ус түгээх, хог цуглуулах болон автобус, галт тэрэгний үйлчилгээний цагийн хуваарь г.м.).

**Санхүүжилт ба жижиг зээлийн тогтолцоо
(Хайрцаг 2 үзнэ үү)**

- Санхүүгийн тусламж үзүүлэхдээ ядуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд хүрч чадах засгийн газрын дэмжлэгтэй, хувийн хэвшлийн болон ТББ-ын санхүүгийн байгууллагаар дамжуулан олгохыг харгалзах.
- Олон нийтэд түшиглэн төслийг хэрэгжүүлэхдээ хадгаламж, нөөц эх үүсвэрийг хуримтлуулахадаа эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх.
 - Дараахь зүйлүүдээр эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан . Үүнд:

үзүүлэлт болон нөхцөлүүдийг боловсруулан гаргасан. Эдгээр үзүүлэлтүүд нь нэмэлт газар авах зорилгоор эмэгтэйчүүдийн нэрийг давхар ашиглах боломжийг эрэгтэйчүүдэд олгохгүй байх явдлыг хангаж байгаа юм.

Эмэгтэй худалдаачид эмэгтэйчүүдийн ТББ-ын тусламжтайгаар дэлгүүрийн менежмент, худалдааны тусгай зөвшөөрөл авах, татвар ба замын хураамж, мөн худалдаа хийх хэрэгслийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх чиглэлээр сургалтанд хамрагдсан байна. Үүнээс гадна үйлчилгээний эрэлт хэрэгцээг өндөр байлгах үүднээс эмэгтэйчүүд, охидуудад энэхүү цэгүүдийг үйлчилгээгээг ашиглах сонирхлыг нь төрүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг зохион байгуулжээ.

Үерийн үеэр эмэгтэйчүүдэд зориулсан байр хэсгүүд байгуулах

Эмэгтэйчүүд өөрсдөө хорогдох байрны байршлыг сонголт болон загварыг хийхэд оролцсон. Түүнчлэн эмэгтэйчүүдэд зориулсан хэсэг болон бие засах газар, мөн ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ, хэрэгсэл шаардлагатай байгааг харгалзан үзсэн.

- Санхүүжилтийн менежмент (хэрэглэгчийн төлбөр, бэлэн мөнгө, түүнийг орлох бараа, өөрийн биеэр төсөлд оролцох г.м.)
- Нэн ядуу, өрх толгойлсон эмэгтэйчүүд болон бусад нийгмийн үйлчилгээнээс орхигдох хандлага бүхий эмзэг гэр бүлүүдэд үзүүлж болох хөнгөлөлттэй арга хэмжээ
- ХБОС-ны зээлийн буюу олон нийтэд түшиглэсэн эргэлдэх сантай холбох боломж (Хайрцаг 2 үзнэ үү). Зээлийн эргэн төлөх хуваарь нь хот суурин газрын албан бус салбарын орлогын тогтмол бус байдлыг харгалзах ёстой.

- Зээлийн барьцааны нөхцөлийг хангахын тулд бараа бүтээгдэхүүн (хангах нийлүүлэгчийн тусгай зөвшөөрөл г.м.)-ийг ашиглахыг зөвшөөрөх.

Эмэгтэйчүүдийн оролцоо (Хайрцаг 3 үзнэ үү)

- Төслийн хэрэгжилт болон ХҮ-нд эмэгтэйчүүдийг оролцуулах асуудлыг шийдвэрлэх зорилгоор оролцооны стратегийг боловсруулах. Эмэгтэйчүүдийн оролцооноос төслийн үр дүн хамаардаг гэсэн хүлээлтээс зайлсхийх бөгөөд эмэгтэйчүүд байнга цагт хавчигдаж, санхүүгийн хүндрэлтэй тулгардаг тул амьдралд ойр цагийн хуваарь боловсруулах. Стратегид дараахь зүйлүүдийг оруулсан байна. Үүнд:

Хайрцаг 2

Энэтхэгт олон нийтэд түшиглэсэн санхүүгийн байгууллага ба ТББ-д үзүүлж буй тусламж: ядуу эмэгтэйчүүдийг боломжийн орон сууцаар хангах хэрэгцээ

КЕЙС СУДАЛГАА

Энэтхэгт орон сууц ихээхэн дутмаг байдаг: зөвхөн хот суурин газарт гэхэд л эрэлт хэрэгцээ-нийлүүлэлтийн зөрүү ойролцоогоор 17 сая нэгж байдаг. Энэтхэгийн олон хотод ядуучуудын хороолол давамгайлж байгаа нь үүнийг харуулж байна. Ядуучуудын хорооллын оршин суугчид жилд 9-10 хувиар нэмэгдэж байна. Оромж болон наад захын үйлчилгээ байхгүй байгаа зэрэг амьжиргааны дорой нөхцөл байдалд эмэгтэйчүүд ба хүүхдүүд хамгийн их өртдөг байна. Үүнийг шийдвэрлэх зорилгоор засгийн газар зах зээлийн баримжаатай орон сууцны санхүүгийн байгууллага (ОССБ) болон ядууралд хандсан олон нийтэд түшиглэсэн санхүүгийн байгууллага (ОНТСБ)-ыг хөхүүлэн дэмжиж байна. Мөн дундаж орлоготой өрхүүдтэй ажилладаг орон сууцны санхүүжилтийн хувийн компаниуд байдаг. Үүнээс гадна зарим үед ТББ болон ОНТТБ бага орлоготой ард иргэдэд ядуучууд, ялангуяа эмэгтэйчүүдэд санхүүжилт олгоход туслалцаа үзүүлж байна. Энэтхэг улсын Орон сууц санхүүжилтийн төсөл (1997) нь эдгээр төрөл бүрийн орон сууцны санхүүжилтийн байгууллагуудад дэмжлэг үзүүлж байна. Энэ нь ОССБ-ын илүү олон нийт рүү хандсан ба ядуучуудад зориулсан ОНТСБ ба ТББ/ОНТБ-д зээл олгох үйл ажиллагааг нь дэмжих оролдлогыг хийжээ. Нөгөө шинэлэг хандлага нь «ядуучуудын хорооллын сүлжээ» бөгөөд үүнд засгийн газар, ард иргэдийн байгаль орчны менежментийг хариуцдаг хувийн үйлдвэрүүд болон ТББ/ОНТБ-ууд ядуусын хорооллын нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулж байна. Жишээлбэл Ахмедабадад засгийн газрын дэмжлэгтэй Ахмедабад хотын захиргааны корпораци (АХЗК), ойролцоо байрлах хувийн үйлдвэрүүд (жишээ нь гурилын үйлдвэр) болон ТББ/ОНТБ-аар үйлчлүүлдэг ард иргэд бүгдээрээ гарах бүх зардалыг төлөхөд хувь нэмрээ оруулдаг байна. Ядуучуудын хорооллыг тохиромжтой байдлаар багцлан хувааж нэр хүнд бүхий үйлдвэрүүд болон ТББ-ын консорциумуудыг АХЗК-аас тогтоосон ажлынхүрээнд ард иргэдийн өмнөөс тухайн ажлыг гүйцэтгэхээр тендерт оролцохыг уриалжээ. ТББ/ОНТБ нь ядуусын хороололд оршин суугчдийг төлөөлсөн. Ядуучуудын хороолол нь нөхцөлөө сайжруулахын тулд өрх бүр тус тус 2,100 рупий хандивлах ёстой. Хэрэв тухайн өрхийн хуримтлал нь хангалтгүй бол зээлийг Хувиараа бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн нийгэмлэг (ХБЭЭН)-ийн банк болон Эмэгтэйчүүдийн Дэлхийн Банкны анд нөхөд зэрэг санхүүжилт олгодог ТББ-аас зээл олгодог байна. Эмэгтэйчүүд бичил санхүүгийн байгууллагуудын орон нутгийн агентуудын хувьд тухайн өрх бүрээс санхүүгийн эх үүсвэрийг дайчлахад гол үүрэг гүйцэтгэж байна.

- *Зохион байгуулалтын бүтэц:* Шаардлагатай үед (ялангуяа олон нийтэд түшиглэсэн аргыг ашиглаж байгаа үед) эмэгтэйчүүдийн болон манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тэднийг оршин суугчдын бүлэг хэлбэрээр зохион байгуулах асуудлыг харгалзах. Эмэгтэй, эрэгтэй гишүүдээс бүрдсэн бүлэг байгуулах хүсэлтэй байгаа тохиолдолд эдгээр бүлгүүдийн гүйцэтгэх хороонд эмэгтэйчүүдийн тоог хувь заах зэрэг асуудлыг харгалзах.
- *Бүлгийн дүрэм:* орон нутгийн иргэдийн албан ёсны бүлгийг зохион байгуулж байгаа тохиолдолд гишүүдийн эрх, үүргийг тодорхой зааж өгөх. Хэрэглэгчийн эрх, үүрэгтэй холбоотой зөрчлийг шийдвэрлэх гомдол барагдуулах механизмыг бий болгох. Тохиролцоог дүрмэнд тусгаж баримтжуулах.
- *Барилга:* Ажлын нөхцөл нь эмэгтэйчүүдийн оролцоог хөхүүлэн дэмждэг (тухайлбал, эрэгтэй эмэгтэй хүмүүс адил цалин хөлс олгох, барилгын улирал, бие засах газар болон хүүхэд асрах газар) байх явдлыг хангах.
- *Ажлын байр, тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээ:* Ажлын байр, тоног төхөөрөмжүүдийн ажиллагаа, засвар үйлчилгээг хийх ажилд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн адил тэгш сургах
- *Ариун цэвэр ба эрүүл ахуй:* Эмэгтэйчүүд болон нөхөр, эрэгтэй удирдагчдыг энэ ажлуудад татан оролцуулах
- *Хяналт ба үнэлгээ (ХҮ):* Эрэгтэй, эмэгтэй төслийн ашиг хүртэгчдэд бүгд өөрсдийн саналаа хэлэх, санал бодлоо солилцох механизмыг боловсруулах.
- *Эмэгтэйчүүдийн ТББ/ОНТБ:* Төслийн хэрэгжилт болон ХҮ-ний үе шатанд эмэгтэйчүүдийн оролцоог хөхүүлэн дэмжих байгууллагуудтай хамтран ажиллах.

ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэх хороодод

эмэгтэйчүүдийн

оролцооны

нэмэгдүүлэх,

эмэгтэйчүүдэд

зориулсан

манлайллын сургалт

зохион байгуулах

Хөдөлмөр эрхлэлт

- Төслийн хүрээнд эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэх эрх тэгш боломж олгох (барилга; барилгын материалын үйлдвэрлэл; жижиг болон дунд оврын хог цуглуулах аж ахуйн нэгж, арилжаа, хогийг дахин боловсруулах аж ахуйн нэгжүүд г.м.)

- Гэрээрээ бизнес эрхэлж буй эрэгтэй эмэгтэйн аль нь ч эрэгтэй эмэгтэй хүмүүсийг тусгаарлах дүрэм журмын дагуу гадуурхдаггүй байх явдлыг хангах.
- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэх илүү их боломж олгох үүднээс шинэ орон сууцнуудыг аль болох зах зээл буюу үйлдвэрийн газартай ойр байрлуулах.

Орон сууцны өргөдөл гаргахад анхаарах асуудлууд

- Шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахдаа байнгын орлоготой бус эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахгүй байх ёстой. Хэрвээ тийм биш бол албан ёсны хөдөлмөр эрхлэлтийн салбарт төлөөлөл нь бага эмэгтэйчүүдэд сөргөөр нөлөөлөх магадлалтай. Зөвхөн өрхийн тэргүүний тогтмол орлогыг авч үзэхийн оронд өрхийн бүх гишүүдийн тогтмол бус орлогыг тооцох зэрэг орлогын уян хатан тооцоог харгалзах. Өөр нэг хувилбар нь эдгээр хүмүүст бага орлоготой хүмүүст зориулсан орон сууц олгох асуудлыг харгалзах.

Хайрцаг 3

Энэтхэг улсын Орон сууцны санхүүжилтийн төсөл, 1997: Гэрээр хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн орон сууцны нөхцөлийг сайжруулах ба ядуурлыг иж бүрнээр бууруулахад дэмжлэг үзүүлэх

КЕЙС СУДАЛГАА

2-р хайрцагт дурдсан Орон сууцны санхүүжилт төсөл нь мөн бага орлоготой эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд орлого хуримтлуулах боломжийг олгодог. Энэ талаар 2 арга зам байна. «Ажлын байр-орон байр» хэмээх арга нь гэрээрээ даавуу нэхэж үйлдвэрлэл явуулдаг ядуучууд, гол төлөв эмэгтэйчүүдийг дэмждэг. Засгийн газраас томилогдсон хатгамалын буюу гар урлалын нийгэмлэгүүд болон корпорацууд нь орлогыг нь нэмэгдүүлэх зорилгоор зээлийн санхүүжилт олгодог байна. Засгийн газар орон байр эсвл ажлын байраар хангадаг. Төсөл, газар эзэмших эрхийг гуравдагч талд худалдах буюу түрээслэх явдлыг гаргахгүй байх үүднээс наад зах нь арван жилийн хугацаатай санхүүжүүлэлт олгож энэ нь ядуу хорооллын оршин суугчдад сайн орон сууцтай болох, ажилдаа тогтвор суурьшилтай ажиллахад түлхэц өгч байгаа юм. Нөгөө нэг хандлага нь «ажлын байр дахь хөдөлмөрийн бүтээмж,» бөгөөд энэ нь бага орлоготой эмэгтэйчүүдэд

- Өрх толгойлсон эмэгтэйчүүд ба хамтран амьдрагчдыг зөвшлийн үндсэн дээр хамтран ажиллах боломжийг олгох
- Ядуучууд, эмзэг бүлгүүд болон өрх толгойлсон эмэгтэйчүүдэд хөнгөлттэй шалгуур үзүүлэлт хэрэглэх. Боломжтой бол тэдний тоо хувийг тогтоох
- Боловсролгүй буюу бичиг үсэгт тайлагдаагүй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн өргөдөл гаргахыг хөхүүлэн дэмжих үүднээс цаас хүнд суртлын олон шат дамжлагыг багасгах.

Орон сууц эзэмших эрх (мөн хайрцаг 3-г үзнэ үү)

- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хоёулангийнх нь хувьд түрээс буюу эзэмшлээ баталгаажуулахыг дэмжих. Мөн орон сууцыг нэлээд урт хугацаагаар эзэмших буюу түр эзэмших эрх нь энэхүү таатай байдлыг буй богдог. Эмэгтэйчүүдийн орон сууцаа тосгох, жижиг үйлдвэрлэл явуулах, улмаар орлого хуримтлуулах хүсэл эрмэлзлийг төрүүлдэг.
- Хотын захад орон сууцны шинэ төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бол ядуу өрхүүдийг

орлогоо нэмэгдүүлэх боломжыг олгодог. Хайрцаг 2-т дурьдсанаар орлого хуримтлуулах боломж олгох зорилгоор бүлгээр зээл олгох явдлыг дэмжихийн тулд Хувиараа бизнэс эрхлэгч эмэгтэйчүүдийн Холбооны банк (ӨАЭХБ) зэрэг олон нийтэд түшиглэсэн шинэлэг санхүүгийн байгууллагуудтай хамтарч ажиллаж байна. Өрхийн эмэгтэй гишүүдийн нэр дээр хөрөнгө худалдаж авах нь цөөн тул энэ нь ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд чухал алхам. Иймд эмэгтэйчүүд өөрийн нэр дээр дэлгүүр, морин тэрэг, газар буюу байшин зэрэг үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, мөн түүнчлэн капитал, банкин дахь данс, хувьцаа болон хадгаламжийн гэрчилгээ зэргийг нэр дээрээ авах нь тэдэнд бүрэн эрх олгоход ихээхэн чухал. Түүнчлэн ур чадварыг хөгжүүлэх сургалт явуулах, түүхий эдийн эх үүсвэр олоход тусалцаа үзүүлэх, сайн төхөөрөмжөөр хангах, зах зээлтэй холбоо тогтоож өгөх зэргээр зээлдэгчдийг чадавхжуулдаг.

бүгдийг шинэ газар луу нүүлгэхийн оронд эрэгтэй эмэгтэйн алины ч нэр дээр газар эзэмших эрх олгож оршин суугаа газрын үйлчилгээг өргөтгөх талаар бодолцох нь зүйтэй. Ингэснээрээ ядуучууд нь урьд өмнө нь амьдарч байсан, амьжиргааны эх үүсвэрээ олж байсан хотын төв дахь орон сууц руу буцаж ирэх боломжтой болох юм.

Мэдээлэл өгөх, маркетингийн стратеги (мөн тайлбар зүүлт 2 үзнэ үү)

ЗӨВЛӨМЖ

Хот суурин газрыг

усаар хангах

үйлчилгээг 24

цагийн турш үзүүлэх

боломжгүй бол усыг

шөнө түгээхээс

зайлсхийх нь зүйтэй.

Учир нь эмэгтэйчүүд

усаа зөөж байхдаа

халдалганд өртөх нь

элбэг тохиолддог.

■ Жендэрийн хөдөлмөрийн хуваарь дээр үндэслэн холбогдох бүлгүүдэд байгаль орчноо хамгаалах талаар мэдээлэл өгөх. Жишээ нь хэрэв эмэгтэйчүүд хог хаягдлыг цэвэрлэх асуудлыг хариуцаж байвал олон нийтийн мэдээллийн кампанит ажлыг тэдэн рүү чиглүүлж тэдэнтэй харилцах мэдээллийн стратегийг боловсруулах хэрэгтэй.

■ Мэдээлэл буюу маркетингийн кампанит ажлын зорилтот бүлэг нь эмэгтэйчүүд байх юм бол тэдэнтэй хамтран ажиллаж илүү үд дүнд тулд эмэгтэй мэдээллийн ажилтанг ажиллуулах.

■ Мэдээлэлийн чиглэлээр эмэгтэйчүүдийн ТББ/ОНТБ, маркетингийн чиглэлээр маркетингийн туршлагатай аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах

Сургалт

■ Орлого хуримтлуулах, цаашид бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь туслах зорилгоор ур чадварыг дээшлүүлэх сургалтыг төсөлтэй холбоотой барилгын чиглэлийн сургалттай хослуулах (туйпуу ерөх, мужаан, гагнуур г.м.).

■ Нэн ядуу бүлгүүдийн сургалтанд хамрагдах сонирхлыг хөхүүлэн дэмжих үүднээс тэдэнд сар бүр тэтгэмж олгох асуудлыг анхааралдаа авах.

■ Орон сууц хөгжлийн чиглэлээр газартай холбоотой хууль эрх зүйн асуудал болон өмчлөх эрхийн талаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд сургалт явуулах асуудлыг анхаарах.

■ Төслийн бүх эмэгтэй, эрэгтэй ажилтнуудад жендэрийн талаар сургалт явуулах.

■ Хэрэгжүүлэгч агентлаг болон төслийн ажилтнуудад жендэрийн мэдрэмжтэй ХҮ-ний чиглэлээр сургалт явуулах.

■ Ашиг хүртэгч оролцогчдыг сургахдаа ТББ/ОНТБ-тай нягт уялдаатай ажиллах.

Төслийн бүтэц, хүрээ

Зорилго

■ Салбар болон төслийн зорилтууд нь ядуурлыг бууруулах, хүний хөгжил болон жендэрийн тэгш эрхийг хангахад чиглүүлэх.

Арга зүй

■ Жендэрийн асуудалд мэдрэмжтэй ХБОС-ны төслийн чиглэлээр туршлага хангалтгүй байгаа тохиолдолд туршилтын төсөл хэрэгжүүлэхийг судалж үзэх.

■ Төслийг хаана хэрэгжүүлэх вэ гэдгийг хэрэгжүүлэгч байгууллага болон олон нийтийн санал дээр үндэслэн тогтоох.

Ядуурлыг бууруулах ба эмэгтэйчүүдийн эрх мэдлийг дээшлүүлэх

Ядуурлыг бууруулах ба эмэгтэйчүүдийн эрх

■ мэдлийг дээшлүүлэхэд чиглэгдсэн санаачлагыг орлого нэмэгдүүлэх, бичиг үсэг тайлагдах, бусад үйл ажиллагаануудтай холбох, дэмжих (одоо хэрэгжиж буй, эсвэл цаашид хэрэгжүүлэхээр төвлөж буй бичил санхүүгийн төслүүд, үйлчилгээний талаарх мэдээлэл өгөх зэрэг г.м.) үйл ажиллагаануудыг төслийн бүрэлдэхүүн хэсэг болгон хэрэгжүүлэх.

Төслийн боловсон хүчин, төслийн хуваарь, худалдан авах, төсөвлөх

■ Төслийг хянах албан тушаалд эмэгтэйчүүдийг оролцуулах

■ Төслийн ажлын алба болоод гүйцэтгэгч агентлагуудад эмэгтэйчүүдийг олноор ажиллуулах.

ЗӨВЛӨМЖ

Эмэгтэйчүүдэд

илүү үр дүнтэй

хүрэхийн тулд

эмэгтэй мэдээллийн

ажилтанг

ажиллуулах.

Хайрцаг 4

Энэтхэг дахь Карнатакын хотжуулалтын хөгжил ба далайн эргийн байгал орчны менежментийн төсөл 1999: Эмэгтэйчүүдийн оролцоо болон ядуурлыг бууруулахад анхаарлаа хандуулах нь

**КЕЙС
СУДАЛГАА**

Энэтхэг улсын хот суурин газрын хөгжлийн цогц төсөл болох Карнатакийн хотжилтын хөгжил ба эргийн байгаль орчны менежментийн төсөлд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, ялангуяа харьцангуй их ачаалалтай ядуу эмэгтэйчүүдтэй хамтран ажиллах чиглэлээр ядууралтай тэмцэх тодорхой арга хэмжээг тусгасан байна. Уг төсөл нь Карнатака мужийн баруун хэсгийн арван хотод хүний наад захын хэрэгцээг хангахад шаардлагатай хот суурин газрын дэд бүтэц, үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийж хот суурин газрын менежментийг бэхжүүлэх, бодлогын өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулсан. Төсөл зургаан бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд: (I) ядуурлыг бууруулах талаар орон нутгийн иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, оролцоог хангах хөтөлбөр / ЯБТОНИМДООХХ/ болон ядуусын хорооллын нөхцөлийг сайжруулах хөтөлбөрөөр дамжуулан орон нутгийн засаг захиргааны ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх; (II) усны хангамжийг нөхөн сэргээх ба өргөтгөх; (III) хаягдал усны менежмент, борооны ус урсгаж хатаах болон хатуу хогны менежмент хэрэгжүүлэх замаар хот суурин газрын орчин тойрныг сайжруулах; (IV) гудамж, гүүр сайжруулах; (V) далайн эрэг орчины менежмент ба (VI) төслийн менежмент болон бусад дэмжлэг эдгээр болно. Амьдрах нөхцөл нь муу болон хот суурин газрын үндсэн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа нь тухайлбал эмэгтэйчүүд болон хүүхдүүдэд сөргөөр нөлөөлдөгийг нийгмийн үнэлгээгээр тогтоожээ. Утаа униар ихтэй, бохир нөхцөлтэй гэрт байдаг, эмнэлгийн үйлчилгээнд хүрч чаддаггүй эмэгтэйчүүд илүү дарамтад орж өвчин эмгэгд нэрвэгдэх нь их байдаг байна. Ус болон өвчин тээгч шавьж хорхойгоор дамжих халдварт өвчнүүдэд хүүхэд

- Үйлчилгээний байгууллагуудын бүх түвшинд жендэрийн сургалт явуулах.
- Ажлын гэрээнд эмэгтэй ажилчдын хувь хэмжээний доод хязгаарыг тогтоож насанд хүрээгүй хүүхдийг хөдөлмөрийг үл тэвчих.
- Олон нийтэд түшиглэсэн хандлага арга зүйг ашиглаж «суралцах» хандлагыг (эмэгтэйчүүдийн байгууллагуудад зориулсан сургалтын төсөв, зөвлөгөө өгөх үйлчилгээний төсөв г.м.) хөхүүлэн дэмжиж тусгайлан төсөв гаргах.

Мониторинг ба үнэлгээ

- ХҮ-ний ажлыг зохион байгуулах. Үүнд: (I) төслийн ажилтнуудын хэрэгжүүлэх дотоод ХҮ; (II) ТББ буюу зөвлөхүүдийн гадаад

ихээхэн өртдөг байна. Усны хоолойд холбогдоогүй өрхийн эмэгтэйчүүд болон оксидууд ус зөөхөд цаг зарцуулдаг байна. Төслийн хүрээнд дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх замаар эрүүл ахуй ба ариун цэврийг сайжруулсанаар эмэгтэйчүүдийн эрүүл мэнд болон хөдөлмөрийн бүтээмжид ихээхэн сайн нөлөө үзүүлдэг байна. Гэхдээ төслийн нааштай үр дүн нь үүгээр хязгаарлагдахгүй. ЯБТОНИМДООХХ-ийн нэг хэсэг нь эмэгтэй, эрэгтэй хэрэглэгчид төслийн загвар /төлөвлөгөөг гаргах, төслийн хэрэгжилт, үйл ажиллагаа ба хэрэгжүүлэлт болон хяналт, үнэлгээ (ХҮ)-ний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, санал авах механзмаар дамжуулан төсөлд оролцох боломж олгоно. Үүнийг дүүрэг тус бүрийн ТББ-ын консорциумаар дамжуулан хэрэгжүүлнэ. Шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн төлөөлөл чухал гэдгийг ЯБТОНИМДООХХ- хүлээн зөвшөөрч байгаа юм. Эмэгтэй шийдвэр гаргагчдын сүлжээ, үүний дотор хотын зөвлөлийн эмэгтэй дарга болон тухайн холбогдох хотын захиргааны эмэгтэй гишүүд, эмэгтэйчүүдийн ТББ болон нутгийн иргэдийн эмэгтэй төлөөлөгчдэд ЯБТОНИМДООХХ-р дамжуулан мэдээлж байна. Мөн ЯБТОНИМДООХХ- нь төрөл бүрийн сургалт болон мэдлэг түгээх үйл ажиллагаа явуулах, үүний дотор хөгжил дэх эмэгтэйчүүдийн оролцооны чиглэлээр сургалт явуулна. Түүнчлэн ядуу эмэгтэйчүүд болон ядуусын хорооллын нөхцөлийг сайжруулах хөтөлбөрөөс ашиг хүртэнэ. Дэд бүтцийг сайжруулснаар (ус хангамж, ариун цэвэр, хөрс хатаалт, зам засах г.м.) зогсохгүй мөн бүлгийн хадгаламж, зээлийн үйл ажиллагаа, ур чадварыг хөгжүүлэх ба үйлдвэрлэл эрхлэлтийн сургалтыг дэмжиж, төслөөс олгох хөдөлмөр эрхлэх боломжийг олгох юм. Ядуу эмэгтэйчүүд ашиг хүртэх боломжийг хангах үүднээс эдгээр үйл ажиллагааг орон нутгийн ТББ болон нутгийн иргэдийн байгууллагууд хянаж хамтран ажиллана.

ХҮ ба (III) ашиг хүртэгч эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн оролцооны мониторинг.

- Холбогдох бүх үзүүлэлтийг жендэрээр ялгавартай гаргах
- Санал болгож буй үзүүлэлтүүд:
 - Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дунд ХБОС-ны дэд бүтцийн ашиглалт болон ойлголтын түвшин, жишээ нь сэтгэл ханамж, сонгож авсан техникийн багцын талаарх ойлголтын түвшин, ашиглах хэлбэр, хүртээмж, үйлчилгээний цар хүрээ, ариун цэврийн талаарх мэдлэг, ус зөөхөд хэмнэсэн цаг гэх мэт.
 - Төслийн тогтвортой байдал, жишээ нь зардлын нөхөн төлөлт, түүний хуваарилалт, задаргаа, хэрэглэгч бүлгүүдийн гишүүдийн тоог жендэрээр ялгавартай гаргах, зохион байгуулсан хурлын тоо г.м.

- Эмэгтэйчүүдийг чадавхжуулах, жишээ нь зээл авах боломжтой болж байгаа эмэгтэйчүүдийн тоо, эмэгтэйчүүдийн орлогын өсөлт, төслийн сургалтанд хамрагдсан эмэгтэйчүүд ажил эрхлэх боломжтой эсэх

Хайрцаг 5

Бангладешийн Хоёрдогч хотуудын дэд бүтцийн хөгжлийн хоёрдугаар төсөл, 1995: жендэрийг зонхилох чиг хандлага болгох стратеги

КЕЙС СУДАЛГАА

Хотын дэд бүтцийн хөгжлийн хоёр дугаар төсөл нь засгийн газрын төвлөрлийг сааруулах бодлогыг дараах бүрэлдэхүүн хэсгүүдээр дамжуулан дэмжиж хэрэгжүүлсэн. Үүнд: (I) Дэд бүтцийг нөхөн сэргээх (зам, гүүр, хог хаягдлын менежмент, усан хангамж, ариун цэвэр, хотын хөгжил г.м.); (II) ядуусын хорооллын нөхцлийг сайжруулах; (III) бага орлоготой иргэдэд зориулсан орон сууц, газар ашигалалтын төлөвлөлт болон хог хаягдлын менежментийн туршилтын төсөл; (IV) хотын захиргааг дэмжих нэгж, Орон нутгийн Засаг Захиргааны Үндэсний Хүрээлэн болон дөрвөн хотын захиргааг загвар болгон тэдний чадавхийг хөгжүүлэхэд чиглэгдсэн.

Төслийн дунд хэсэгт эмэгтэйчүүдийн оролцоо нь төслийн ядуусын хорооллын нөхцлийг сайжруулах бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд үйл ажиллагаа, тухайлбал эрүүл мэнд, боловсрол, ус хангамж, байгаль орчны сургалт, бүлгүүдийн бүрдэлт, зээл олгох замаар орлого хуримтлуулах зэрэг үйл ажиллагаагаар хязгаарлагдаж байсан нь тогтоогджээ. Төслийн ажилтнууд жендэрийн асуудлыг тодруулан авч үзсэн боловч салбарын шинж чанартай жендэрийн асуудлыг орхигдуулсан.

АХБ-ны Суурийн төлөөлөгчийн газрын ЖХ-ийн мэргэжилтний туслалцаатайгаар төслийг зөв голдрилд оруулж, «эмэгтэйчүүдийн бүрэлдэхүүн хэсэг» байлгахгаас гадна төслийн үйл ажиллагааг жендэрт чиглүүлэх зорилгоор төсөлд хамааралтай ЖХ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулжээ. Уг төлөвлөгөөг боловсруулах зорилгоор АХБ болон Орон нутгийн засаг захиргаа, хөдөөгийн хөгжил болон хоршоодын яамны Орон нутгийн засаг захиргааны Инженерийн Хэлтэс /ОНЗЗИХ/-ийн хооронд сургалт семинар, зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Төлөвлөгөө нь дараахь онцлогтой. Үүнд:

- *ЖХ-ийн зонхилох чиг хандлагыг дэмжих зорилго бүхий бүтэц зохион байгуулалтын арга хэмжээ:* ЖХ-ийн бүх үйл ажиллагааг зохицуулах, үүний дотор ОНЗЗИХ -ийн ЖХ-ийн удирдамжийг бэлтгэх зорилгоор ЖХ-ын гол асуудал болох зөвлөх багийн гишүүнийг томилох.

Баримтжуулах

- Төслийн жендэрийн асуудлыг ЕЯТЗ-д баримтжуулж (төслийн ЖХ-ийн стратеги хэлбэрээр байвал илүү зохимжтой) төслийн загварыг жендерийн мэдрэмжтэй байлгах механизмыг бий болгож түүнийг гүйцэтгэгч агентлаг мөрдөхийг зээлийн гэрээнд тусгах (1-р хүснэгтийг үзнэ үү).

- *Орон нутгийн засаглал дахь жендэрийн асуудал:* Хотын захиргааны тойргийн эмэгтэй даргатай жендэр болон байгаль орчны хороодыг байгуулахад, зөвлөгөө өгөх; тэдгээрийн чадавхийг бэхжүүлэх, эмэгтэйчүүдийг татвар үнэлэх, татвар авах, татварын ажилтанаар ажиллуулах
- *Дэд бүтцийн төлөвлөлт шинээр боловсруулах:* зах болон автобусны буудлын нөхцлийг сайжруулах (хүлээлгийн өрөө, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, бие засах газар, тийз захиалгын газар г.м.)
- *Хөдөлмөр эрхлэлт:* гэрээлэгчдэд эмэгтэй барилгын ажилтан нарыг ажиллуулах санал тавих, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд ажил гүйцэтгэсний нь төлөө адил тэгш хөлс төлөх зарчмыг баримтлах
- *Эмэгтэйчүүдэд зориулсан сургалт:* эмэгтэй, эрэгтэй ашиг хүртэгсэд болон эмэгтэй тойргийн ажилтнуудад байгаль орчин, ариун цэвэр, хог хаягдлын менежмент, эрүүл мэнд ба эрүүл ахуй, задгай жорлон, худаг, олон нийтийн бие засах газар ажиллуулах чиглэлээр тойрогт-тулгуурласан сургалт явуулах
- *Төслийн ахлах ажилтан нарт зориулсан жендэрийн сургалт:* АХБ-ны ЖХ-ийн бодлого, эмэгтэйчүүдийг хөгжүүлэх үндэсний бодлого, засгийн газрын ЖХ-ийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө хөтөлбөр болон ЖХ-ийн үндсэн үзэл баримтлалын талаарх ойлголтыг бэхжүүлэх
- *Жендерийн мэдрэмжтэй хяналт ба үнэлгээ:* жендэрээр ялгаварласан үзүүлэлтүүдийг батлах; өрхийн судалгааны асуулгын загварыг өөрчлөх; хотын захиргааны жилийн тайланг жендэрийн асуудалд илүү анхаарах зорилгоор шинэчлэх.

Мөн түүнчлэн ЖХ үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэхдээ хотын захиргааны тойргын эмэгтэй комиссарын ажлын тодорхой удирдамжгүй байсан бөгөөд хамгийн сүүлд баталсан орон нутгийн засаг захиргааны шинэтгэлийн тухай хуулинд хотын захиргааг орхигдуулсаныг илрүүлжээ. Энэ асуудлаар илүү өндөр төвшинд засгийн газар, АХБ-ны хооронд бодлогын хэлэлцүүлэг явуулсан.

Бодлогын хэлэлцүүлэг

Бодлогын хэлэлцүүлэгээр ямар асуудлыг хөндөх вэ гэдэг нь хэрэгжүүлэгч агентлагуудын жендэрийн асуудлыг хүлээж авч байгаа байдал, асуудлыг шийдвэрлэхэд тэдний туслалцаа, асуудлуудын мөн чанар, хир зэрэг ярвигтай байгаагаас ихээхэн шалтгаална. Зарим тохиолдолд жендерийн судалгаагаар жендэрийн асуудлуудыг шийдвэрлэхэд ХБОС-ны төсөл хэрэгжүүлэх, түүнчлэн хууль эрх зүйн болон бодлогын шинэтгэлийг хийх шаардлагатай байдаг. Бусад тохиолдолд шинэ бодлого буюу хуулийг дэмжих төсөл боловсруулж болно. Ямар ч тохиолдолд төслийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж бусад бодлогуудтай уялдаж зохицож байх ёстой. ХБГО-ын түншүүдтэй бодлогын хэлэлцүүлгийг байнга явуулж байх нь чухал.

Мөн бодлогын хэлэлцүүлгийн үр дүнд ХБГО-ын түншүүд жендэрийн асуудлуудыг ойлгож, хэрэгжүүлэхэд тохиромжтой арга хэмжээ авах, хангалттай нөөц эх үүсвэртэй байх зэрэг үүргийг хүлээнэ.

ХБГО-ын түншүүдтэй төсөл болон бодлогын түвшинд хийх яриа хэлэлцээрийн үед гарч болох зарим асуудлуудыг 2-р хүснэгтэнд тусгасан болно.

Хүснэгт 2

Бодлогын хэлэлцүүлгийн хөтөлбөрийн хувилбар

ГОЛ АСУУДЛУУД	САНАЛ БОЛГОЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ
ХА-ийн жендэр ба оролцооны чадавхийг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> Төслийн хэрэгжилтийн явцад ХА-ийн бүх албан тушаалтан, ажилтан нарт жендэр болон оролцооны чиглэлээр сургалт явуулах талаар техникийн туслалцаа авах. Үндэсний эмэгтэйчүүдийн байгууллагууд, үүний дотор Эмэгтэйчүүдийн Яам зэрэг байгууллагуудын дэмжлэгийг авах.
Засгийн газар-ТББ-ын хамтын ажиллагаа	ХА-ийн үйлчилгээ хүргэх ба стратеги боловсруулах чиглэлээр эмэгтэйчүүдийн ТТБ-тай хамтарч ажиллах боломжийг судлах.
Боловсон хүчин	ХА-ийн эмэгтэй орон тооны ажилтнуудын тоог нэмэгдүүлэх
Төсөв	Санхүүгийн эх үүсвэрийг жендерийн тухай ойлголт болон эмэгтэйчүүдэд зориулсан сургалт, мөн эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэх эрх тэгш боломж олгох чиглэл рүү хуваарилах.
Салбарын ажил	Жендэрээр ялгаварлан үзэх буюу салбарын эрх зүйн болон бодлогын асуудлууд (өв залгамжлалын тухай хууль буюу гэр бүлийн тухай хуулийн эмэгтэйчүүдийн газар болон үл хөдлөх эд хөрөнгө эзэмших эрхийн талаарх ялгаварлан үзэх зүйл заалтууд г.м.)-ыг судлах зорилгоор салбарын ажил зохиох , техникийн туслалцааг санал болгох.
Хууль эрх зүй, бодлогын шинэтгэл	Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төсөлд хууль эрх зүйн болон бодлогын шинэтгэлийг оруулахыг харгалзах (жендэр ба орон нутгийн засаглалын талаарх бодлогын асуудлуудын жишээг хайрцаг 5-аас үзнэ үү).

Хавсралт

Жендэрийн мэргэжилтний ажлын удирдамж

ТБТТ-НЫ ШАТАНД ДАХ СУДАЛГАА	ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН ХҮ-Д ҮЗҮҮЛЭХ ТУСЛАЛЦАА
<ul style="list-style-type: none"> ■ Нийгмийн судалгааны нэг хэсэг болох жендэрийн судалгааг бусад мэргэжилтнүүдтэй хамтарч хийх (нийгмийн ухааны судлаачид, эрүүл ахуйн мэргэжилтэн, олон нийтийн оролцооны мэргэжилтэн). ■ Зорилтот хүн амын сонирхогч талуудын гол бүлгүүдийн нийгэм-эдийн засгийн төлөв байдлыг тогтоож тоо баримтыг жендэрээр ялгавартай судлах. Ядуурал ба жендэрийн хоорондын холбоог судлах. ■ Жендэрийн мэдлэг, хандлага, зуршил, үүрэг, шаардлагууд, хэрэгцээ болон эн тэргүүний асуудлуудын хоорондын ялгаа, мөн хотжилтын хөгжил ба орон сууц хангамжийн салбар дахь жендэрийн ялгаа, ийм ялгаа гарахад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах. ■ Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцох чадавхи болон түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг үнэлэх. ■ Төслөөс жендэрээр ялгаварлаг болзошгүй үр нөлөө болон төслийн ашиг шимийг аль болох ихэсгэх, сөрөг нөлөөг аль болох багасгах хувилбаруудыг үнэлж гаргах. ■ ТБТТ болон төслийг хэрэгжүүлэх үед ашиглаж болох төрийн болон төрийн бус байгууллагууд (ТББ), орон нутаг, ард түмэнд түшиглэсэн байгууллагууд (ОНТБ) болон эмэгтэйчүүдийн бүлгүүдийг тодорхойлох. Тэдгээрийн чадавхид үнэлгээ өгөх. ■ Шаардлагатай үед холбогдох бодлого ба хууль тогтоомж (жишээ нь өв залгамжлалын тухай хууль, ус хэрэглэгчдийн бүлгүүдийн дүрэм журам г.м.)-ийг хянах. ■ Судалгааны үндсэн дээр төслийн жендэрийн мэдрэмжтэй ба оролцооны загвар болон шаардлагатай байгаа бусад салбарын бодлого, шинэтгэлийг боловсруулах. ■ Төслийн бүх үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн идэвхитэй оролцоог дэмждэг, зохицуулдаг ба хангадаг тодорхой арга хэмжээг агуулсан, мөн эмэгтэйчүүдийн онцгой асуудлуудыг шийдвэрлэх төслийн жендэрийн стратегийг боловсруулах. ■ Жендэрийн мэдрэмжтэй ХҮ-ний механизм ба үзүүлэлтүүдийг боловсруулах. ■ Хэрэгжүүлэлт болон ХҮ-ний зөвлөхүүдэд зориулсан ажлын удирдамжийг бэлдэх. 	<ul style="list-style-type: none"> ■ Төслийн жендэрийн стратегийг боловсруулж стратеги байгаа тохиолдолд түүнийг илүү боловсронгуй болгож түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хянаж үзэх. ■ Эмэгтэйчүүдийн төлөөллийг тэгш хангах оруулах зорилгоор төслийн багт эмэгтэй ажилтан авах. Төслийн бүх төвшинд төслийн ажилтан нарт зориулж жендэрийн ойлголтын талаар сургалт явуулах. Жендэрийн ойлголтын тодорхой төвшинг хангах. ■ Шаардлагатай бол эмэгтэйчүүдийг ажилд авахад туслалцаа үзүүлэх. Тэдэнд зориулж жендэрийн сургалт явуулах. Хотжилтын хөгжил ба орон сууц хангамж дахь ашиг хүртэгч эмэгтэйчүүдийн сургалтын хэрэгцээг нь үнэлэх. Эдгээр эмэгтэйчүүдийн хэрэгцээнд тохирсон хотжилтын хөгжил ба орон сууц хангамжийн чиглэлээр техникийн хангалттай ур чадварыг хангах зорилгоор тэдэнд зориулсан орон нутгийн ард түмний төвшний сургалтыг удирдан явуулах. ■ Төслийн хэрэгжилтийн мониторингийн ажилд төслийн багт туслалцаа үзүүлэх. Эмэгтэйчүүдийн оролцоог хангах талаар гарч болох аливаа маргаантай асуудлыг шийдвэрлэхэд туслах. ■ Ашиг хүртэгч эмэгтэйчүүдийн хэрэгцээг үнэлэх (зээл, бичиг үсэгт тайлагдах, орлого хуримтлуулах зорилгоор ур чадвараа дээшлүүлэх сургалт г.м.) төслийн ажлын байранд эдгээр хэрэгцээг шийдвэрлэх практик арга замыг санал болгох. ■ Үр ашгийн мониторинг ба үнэлгээний (YAMU) жендэрийн ялгавартай тоон мэдээллийг цуглуулахад туслах. Олон нийтийн бүлгүүдийн эмэгтэй удирдагчдад Хяналт ба Үнэлгээнд олон эмэгтэйчүүдийг татан оролцуулахад туслалцаа үзүүлэх. Судалгааны үр дүнгээс хамааран төслийн хэрэгжилтэнд анхаарах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх.

Эх сурвалжийн түүвэр

Азийн Хөгжлийн Банк. 2000. *Усан хангамж болон эрүүл ахуйн төслүүд*. Манила: АХБ.

Чант, С. 1996. *Жендер, Хот байгуулалт, орон сууц*. Хабитат II-ийн хэвлэлийн цуврал, Боть 2. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр.

Фонг, Моника, Уэнди Уэйкман, ба Анжана Бушан. 1996. *Усаны, ариун цэврийн жендэрийн гарын авлага*. Жендерийн гарын авлага цуврал Дугаар- 2. Вашингтон: Дэлхийн банк.

Хабитат II вэб хуудас. *Боломжийн оргомж: Эмэгтэйчүүдийн эрх*.

<http://www.cedar.ybuvue.ac.at/habitat/gender/gender.html>

Харьянтинингсик. 1997. *Хот суурин газрын усны хангамж: Эмэгтэйчүүдийн үүргийг хэрэглэгчдийнх нь хувьд судлах туршилт*. Дэлхийн банкинд зориулсан эцсийн тайлан. Жакарта, 12-р сар.

Воронлук, Б., ба Ж. Шалквик. 1998. Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг, 11-р сар. *Эрх тэгш байдлын мэдээлэл #1–17*. Стокгольм: Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг, 11-р сар.

